УНШЛАГА

...хоног тутмын хэвлэл
...оны 04 дүгээр сарын 12
№14 /683/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



**Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг**

566

## Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

**Монгол Улсын Засгийн газрын тогтоол**

581

## Зарим нисэх буудлыг хилийн олон улсын боомт болгох тухай

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын Тамгын Газар

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

162. Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 55 566

163. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 56 566

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

164. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай Дугаар 343 567

165. Зарим нисэх буудлыг хилийн олон улсын боомт болгох тухай Дугаар 344 581

166. Эрүүл мэндийн даатгалын 2011 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай Дугаар 346 582

167. Иргэнд хишиг, хувь хүргэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 347 583

168. Гадаадаас 2011 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Дугаар 348 594

169. 2011 оныг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгох тухай Дугаар 349 597

170. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 350 598

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 03 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэндийн Цогтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Мишигийн Батсуурь, Авирмэдийн Отгонцэцэг, Түндэвийн Энхмаа, Пүрэвдоржийн Соёл-Эрдэнэ нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 03 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон тул Цэндийн Цогт, Авирмэдийн Отгонцэцэг, Түндэвийн Энхмаа нарыг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Пүрэвдоржийн Соёл-Эрдэнийг Өвөрхангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 343 | Улаанбаатар хот |

**"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай**

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг зарчмын хувьд дэмжиж, уг төлөвлөгөөг батлаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт даалгасугай.

2. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангах дэд хороодын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагсугай.

3. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлэх арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай.

а) улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;

б) улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг уул уурхайн бүтээгдэхүүн нийлүүлэх замаар баталгаа гаргаж эх үүсвэр бүрдүүлэх, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагын хөрөнгөөр санхүүжүүлэх болон баталгаа гаргах аргачлалыг боловсруулж, 2011 оны I улиралд

багтаан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун), Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт;

в) Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын санхүүгийн эх үүсвэрийг гадаадын хөнгөлөлттэй зээл тусламж, цэвэр агаарын сан, байгаль хамгаалах сан болон жил бүрийн төсвийн багцдаа тусган шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байхыг Сангийн сайд С.Баярцогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт.

4. Бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах үндэсний мэргэжилтэн, инженер техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилчдын хэрэгцээг тодорхойлон тэдгээрийг бэлтгэх, гадаадад ажиллаж байгаа мэргэжилтэй ажилчдыг татан оролцуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт үүрэг болгосугай.

5. Хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах чиг үүрэг бүхий аж ахуйн тооцоотой "Хот байгуулалт, барилгын зураг төслийн институт" улсын үйлдвэрийн газрыг 2011 оны эхний хагас жилд багтаан байгуулан дүрмийг нь батлан ажиллуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

6. Орон сууцны нийлүүлэлтийг дэмжиж, инженерийн хангамж, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг зохион байгуулах, захиалагчийн хяналт, инженер техникийн болон мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хөтөлбөрт тусгагдсан орон сууцны төсөл, арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий төслийн менежментийн албыг одоо ажиллаж байгаа Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагааг өргөтгөх замаар зохион байгуулж ажиллуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад зөвшөөрсүгэй.

7. Технологийн шинэчлэл хийх замаар Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг жилд 500 мянган тонн ган төмөр, бүтээц үйлдвэрлэх хүчин

чадалтай болгон өөрчлөх ажлыг зохион байгуулж, түүхий эдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төмөртолгойн төмрийн хүдрийн олборлолт, боловсруулалтыг сайжруулан, хүдэр хайлах, төмөр ялган авах технологи нэвтрүүлэх болон шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх талаар тодорхой санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо /Д.Сугар/ -нд даалгасугай.

8. "Шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөрийн хүрээнд баригдах 100 мянган айлын орон сууцны 15-аас доошгүй хувийг дунд болон бага орлоготой иргэдэд зориулан барьж өөрийн өртгөөр нь худалдан борлуулахаар тооцон, барилгын хөрөнгө оруулагч байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

9. Иргэдийн орон сууц худалдан авах чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2011 онд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

10. Хөтөлбөрт тусгагдсан орон сууцны хороолол, зам, гүүр, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн газрын байршлыг тогтоох, газар олгох, чөлөөлөх, барилга барих зөвшөөрөл олгох ажлыг шуурхай шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

11. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

12. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороо болон дэд хороодын ажиллах журмыг 2011 оны I улиралд багтаан баталж мөрдүүлэхийг хороодын дарга нарт даалгасугай.

13. Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д дор дурдсан агуулга бүхий Аравдугаар бүлэг нэмсүгэй:

| Арав. "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт тусгагдсан зарим ажлууд | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 122 | Аймгийн төвүүдэд болон нийслэлд барилгын материалын сорил шинжилгээний иж бүрэн лаборатори | Барилгын материалын түүхий эд, бүтээгдэхүүн болон барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлын шаардлагын түвшинг дээшлүүлэх | Барих-шилжүүлэх | Лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж, түүний холбогдох тоноглол суурилуулах, тохиргоо хийх, сургалт зохион байгуулах | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруу-лалт явуулах |
| 123 | 1990 оноос өмнө баригдсан нийтийн орон сууцны барилгад 700 лифтийг иж бүрнээр шинэчлэх | 1990 оноос өмнө баригдсан нийтийн зориулалттай орон сууцны барилгын лифтийг сайжруулах | Барих-шилжүүлэх | Иж бүрэн тоног төхөөрөмж | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруу-лалт явуулах |
| 124 | Улаанбаатар хотын зарим дүүргүүдэд Мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулах | Улаанбаатар хотод мэргэжилтэй боловсон хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх | Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-шилжүүлэх | Барилгын зураг төсөл, барилга, иж бүрэн тоног төхөөрөмж | Судлан шийдвэрлэх | Уралдаант шалгаруу-лалт явуулах |

14. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний хороо байгуулах тухай" Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 81 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Х.БАТТУЛГА**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Л.ГАНСҮХ**

Засгийн газрын 2010 оны 343 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**"ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга

-Монгол Улсын Ерөнхий сайд С. Батболд

Дэд дарга:

-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга.

Гишүүд:

-Сангийн сайд С.Баярцогт;

-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт;

-Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан (зөвшилцсөнөөр);

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Нямжав;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд Д.Нямхүү;

-Эрүүл мэндийн дэд сайд Ж.Цолмон;

-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун;

-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав;

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр;

-Ерөнхий сайдын зөвлөх Б.Төмөрхуяг;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газрын дарга Б.Баасан;

-Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал (тохиролцсоноор);

-Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав;

-Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын дарга Н.Бямбасүрэн;

-Стандартчилал, хэмжил зүйн газрын орлогч дарга Д.Энхтайван;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын орлогч дарга Д.Ганбат;

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Л.Нямсамбуу (тохиролцсоноор);

-Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал С.Баярбаатар.

Нарийн бичгийн дарга

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд Т.Пүрэвдорж

Засгийн газрын 2010 оны 343 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## "ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ" ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН УДИРДАМЖААР ХАНГАХ ДЭД ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Хөтөлбөрийн "Санхүүжилт болон эдийн засгийн орчин бий болгох" ажлыг хариуцсан дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга

-Сангийн сайд С.Баярцогт

Орлогч дарга -Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун

Гишүүд:
-Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан (тохиролцсоноор);

-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд В.Удвал;

-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав;

-Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал (тохиролцсоноор);

-Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугар;

-Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав;

-Татварын ерөнхий газрын дэд дарга Ж.Батбаяр;

-Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Батбаяр;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ё.Манлайбаяр;

-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга А.Бямбадорж;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Г.Нандинжаргал;

-"Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Алдаржавхлан;

-Монголын Ипотекийн корпорацийн гүйцэтгэх захирал Ц.Энхбаяр;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Сургалт судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны дарга Б.Чинтулга.

Нарийн бичгийн дарга
-Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын орлогч дарга Л.Баяраа

2. Хөтөлбөрийн "Хот байгуулалт, төлөвлөлт, дэд бүтэц, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх" ажлыг хариуцсан дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга
-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга

Орлогч дарга
-Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Мөнхбаатар

Гишүүд:
-Авто замын газрын дарга Б.Энхтөр;

-Ерөнхий сайдын зөвлөх Б.Төмөрхуяг;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын дарга С.Очирбат;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газрын дарга Б.Баасан;

-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Б.Батжаргал;

-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын газрын дарга Т.Цэрэнпүрэв;

-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын дарга А.Эрдэнэпүрэв;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тогтвортой хөгжил, стратегийн төлөвлөлтийн газрын дарга Ц.Банзрагч;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Стратеги төлөвлөлт, бодлогын газрын дарга Л.Чой-Иш;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранцогт;

-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Салбарын хөгжил, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын газрын дарга Б.Ганбаатар;

-Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэд дарга Б.Баярсайхан;

-Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн

барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын дарга Э. Хүрэлбаатар;

-Нийслэлийн газрын албаны дарга Ц.Сандуй;

-"Цахилгаан тээвэр" ХК-ийн Ерөнхий захирал Д.Жаргалсайхан;

-Эрчим хүчний зохицуулах газрын дарга Н.Мягмарсүрэн;

-Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ;

-Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ө.Цэдэндамба;

-Нийслэлийн Ус сувгийн удирдах газрын дарга Б.Пүрэвжав;

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар /тохиролцсоноор/;

-"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бямба-Очир;

-"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Саранжав;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Цэнд-Аюуш.

Нарийн бичгийн дарга
-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны дарга Б.Чинтулга

3. Хөтөлбөрийн "Ажлын байрыг нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих чиглэлээр бүтээн байгуулалтын ажилд дотоодын боловсон хүчнийг түлхүү хамруулах, мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэж, ажлын байраар хангах, шилжилт хөдөлгөөнийг сааруулах" ажлыг хариуцсан дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди

Орлогч дарга
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав

Гишүүд:
-Засгийн газрын ахлах референт М.Сандаг-Очир;

-Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ц.Ням-Осор;

-Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын дарга Н.Бямбасүрэн;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын газрын дарга М.Баасанжав;

-Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хэрэглэгчийн эрхийн газрын дарга Ж.Эрдэнэцогт;

-Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаа;

-Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Б.Ганбат;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны орлогч дарга Ц.Батчимэг;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга М.Отгонбаяр;

-ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуулийн захирал Б.Отгонбаяр;

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Хөдөлмөрийн харилцааны албаны дарга Д.Нармандах (тохиролцсоноор);

-Нийслэлийн Халамж үйлчилгээний газрын дарга М.Уламбаяр;

-Нийслэлийн Хөдөлмөрийн газрын дарга Б.Сүнгээ;

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын орлогч дарга Д.Пүрэвдорж.

Нарийн бичгийн дарга

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга Ш.Отгонхундага

4. Хөтөлбөрийн "Агаарын бохирдлыг бууруулах, суурин газрын тоос, хөө хаягдлыг багасгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг сурталчлан мэдээлэх, сургалт зохион

байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, доноруудтай хамтран ажиллах" ажлыг хариуцсан дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга
-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх

Орлогч дарга
-Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Ганболд

Гишүүд:
-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын дарга С.Очирбат;

-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын дарга А.Эрдэнэпүрэв;

-Ойн газрын дарга М.Тунгалаг;

-Усны газрын дарга Ц.Бадрах;

-Авто тээврийн газрын дарга Б.Цэнгэл;

-Озоны үндэсний албаны дарга Ц.Адъясүрэн (тохиролцсоноор);

-Нийслэлийн байгаль хамгаалах газрын дарга Ю.Дэлгэрмаа;

-Монголын байгаль орчны ТББ-ын холбооны ерөнхийлөгч Ж.Батболд /тохиролцсоноор/;

-Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Цэцэгсайхан;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Н.Итгэл;

-Нийслэлийн агаарын чанарын албаны мэргэжилтэн Ц.Мөнхбат.

Нарийн бичгийн дарга
-Нийслэлийн агаарын чанарын албаны дарга Д.Мөнхцог

5. Хөтөлбөрийн "Хөдөөгийн хөгжил болон үйлдвэржилтийг дэмжих" ажлыг хариуцсан дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай

Орлогч дарга:
-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ

Гишүүд:
-Эрүүл мэндийн дэд сайд Ж.Цолмон;

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Нямжав;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Бадарч;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын газрын орлогч дарга Р.Эрдэнэцэцэг;

-Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Ц.Ням-Осор;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэд дарга Б.Баярсайхан;

-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Салбарын хөгжил, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Ц.Базар;

-Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал О.Лхагвадорж (тохиролцсоноор);

-Жижиг, дунд үйлдвэрийн хөрөнгө оруулалт, экспортын үндэсний нийгэмлэгийн ерөнхийлөгч Г.Энхболд /тохиролцсоноор/;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Бямбасайхан;

-Нийслэлийн хөдөө аж ахуйн газрын дарга Р.Зоригт;

-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Хөдөөгийн бичил ба жижиг, дунд бизнесийг дэмжих хэлтсийн дарга Н.Долгормаа /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга
-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү

6. Хөтөлбөрийн "Тэрийн зуух-яндан, түлшний бүтэц, шаталтын технологийг өөрчлөн сайжруулах, нам даралтын уурын зуухнуудад технологийн шинэчлэл хийх, гэр, орон сууцны дулаалгыг сайжруулах" ажлыг хариуцсан дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга
-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт

Орлогч дарга
-Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Ганболд

Гишүүд:
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулга;

-Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга М.Оюунчимэг;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Энхтуяа;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга Ш.Отгонхундага;

-Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин;

-Эрчим хүчний газрын дарга Ц.Баярбаатар;

-Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Д.Мандах;

-Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга Д.Гүньбазар;

-Стандартчилал, хэмжил зүйн газрын орлогч дарга Д.Энхтайван;

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажилтан Т.Булган (зөвшилцсөнөөр);

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Сургалт судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны орлогч дарга Я.Гэрэлцэцэг;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн

бодлогын хэлтсийн мэргэжилтэн Ч.Цогтсайхан;

-ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн багш, доктор, профессор Ц.Намхайнням;

-ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн багш, доктор, профессор С.Батмөнх;

-Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал С.Баярбаатар;

-Монголын Мянганы сорилтын сангийн "Цэвэр агаар" төслийн гүйцэтгэх захирал С.Мангал;

-Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын Барилга, нийтийн аж ахуйн албаны дарга Д.Гантулга;

-Монголын ус, цаг уурын нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч, доктор Б.Түвдэндорж /тохиролцсоноор/;

-Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар /тохиролцсоноор/;

-Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Л.Алтангэрэл.

Нарийн бичгийн дарга
-Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын дарга Б.Эрдэнэпүрэв

7. "Шилжилт хөдөлгөөн болон хүн амын нүүдэл суурьшлыг зохицуулах хууль, эрх зүйн орчин бий болгох, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, газар олголтыг зохицуулах" ажлыг хариуцсан салбар дундын зохицуулах дэд хорооны бүрэлдэхүүн:

Дарга
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан

Орлогч дарга
-Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Баатарзориг

Гишүүд:
-Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан (зөвшилцсөнөөр);

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд А.Гансүх;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд Д.Нямхүү;

-Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг-Очир;

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Мөнхбаатар;

-Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Б.Ганбат;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын орлогч дарга Д.Мөнхбаатар;

-Нийслэлийн Цагдаагийн газрын дарга С.Баатаржав;

-Нийслэлийн Газрын албаны дарга Ц.Сандуй;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга О.Машбат;

-Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Баярбат.

Нарийн бичгийн дарга
-Улсын бүртгэлийн ерөнхий газрын орлогч дарга С.Энхбаатар

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 344 | Улаанбаатар хот |

**Зарим нисэх буудлыг хилийн олон улсын боомт болгох тухай**

Монгол Улсын хилийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Чойбалсан, Ховд аймгийн Ховд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын нисэх буудлуудыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт байхаар тогтоосугай.

2. Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын

нисэх буудлын хилийн олон улсын боомтыг 2012 оны 5 дугаар сараас нээн ажиллуулсугай.

3. Чойбалсан, Ховд, Даланзадгад, Мөрөн хотын нисэх буудлуудыг хилийн олон улсын боомт болгосонтой холбогдуулан хил хамгаалах болон хилийн мэргэжлийн хяналтын байгууллагуудын орон тоо, шаардагдах хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** **Х.БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 346 | Улаанбаатар хот

**Эрүүл мэндийн даатгалын 2011 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай**

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1, 8.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2011 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тогтоосугай.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцдаг даатгуулагчийн сарын шимтгэлийн хэмжээг 670 төгрөгөөр, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 670 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний сарын шимтгэлийн хэмжээг 5360 төгрөгөөр тус тус тогтоож, 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын 2010 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2009 оны 12

дугаар сарын 30-ны өдрийн 374 дүгээр тогтоолыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЛАМБАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Дугаар 347 Улаанбаатар хот

**Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.1, 17.4, Хүний хөгжил сангийн 2011 оны Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2010 оны 67 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн батлсугай.

2. Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хүний хөгжил сангаас хөрөнгө зарцуулах журам"-ын 3.3, 3.4.2 -ыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

"3.3. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Сангийн яамны Төрийн сангийн газар хянан үзээд бэлэн мөнгөөр хүртэх хишиг, хувийн санхүүжилтийг аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хүний хөгжлийн сангаас иргэнд хишиг, хувь хүртээх санхүүжилтийн дансанд, сургалтын төлбөр хэлбэрээр хүртэх хишиг, хувийн санхүүжилтийг Сургалтын төрийн сангийн дансанд, эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хүртэх хишиг, хувийн санхүүжилтийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн эрүүл мэндийн даатгалын сангийн дансанд Монголбанк дахь Хүний хөгжил сангийн данснаас тус тус шилжүүлнэ."

"3.4.2. иргэн бэлэн бус (сургалтын төлбөр болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл гэх мэт)-ээр хишиг, хувь хүртэхээр сонголт хийсэн бол иргэн бүрийн "Хүний хөгжил сан" дэвтэрт бичилт хийж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дансанд мөнгийг шилжүүлнэ."

3. Дараахь арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай:

а) Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулахтай холбогдуулан уг ажлыг дуусталхи хугацаанд санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 5 ажилтан, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 5 ажилтан, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 6 ажилтан, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн шинээр байгуулагдсан хороодод 11 ажилтан, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст 60 гэрээт ажилтныг нэмж ажиллуулах, шинээр нэмэгдэж байгаа ажилтнуудын цалин хөлсний зардал болон зайлшгүй шаардлагатай зарим техник хэрэгсэл худалдан авахад зориулж 538.3 (таван зуун гучин найман сая гурван зуун мянган) сая төгрөг, 2011 онд иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбоотой асуудлаар нийгмийн ажилтнуудын сургалт зохион байгуулах, хууль тогтоомж сурталчлахад зориулж 60.0 (жаран) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргаж, цаашид улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх;

б) Хүний хөгжил сангаас 2010 онд хуваарилагдсан хишиг, хувиа тухайн ондоо багтаан аваагүй иргэдийн хишиг, хувийг 2011 онд саадгүй нөхөн олгож, холбогдон гарах зардлыг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлэх.

4. Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулахад улсын б ртгэлийн болон нийгмийн халамжийн байгууллагад бүх талын дэмжлэг үзүүлж, шаардлагатай тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хүний нөөц, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Иргэний шинэчилсэн бүртгэлд Монгол Улсын иргэнийг бүртгэх, Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх ажлын дүнг 2012 оны 2 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай" Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 65 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны орон тооны хязгаарыг "60" гэж тогтоосныг "65" гэж, "Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай" Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 46 дугаар тогтоолын 3

дугаар зүйлд Сангийн яамны орон тооны хязгаарыг "136" гэж тогтоосныг "141" гэж тус тус өөрчлөн, "Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2010 оны 3 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,**
**ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Т.ГАНДИ**

Засгийн газрын 2010 оны 347 дугаар
тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ХИШИГ, ХУВЬ ХҮРТЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын иргэн (цаашид "иргэн" гэх) Хүний хөгжил сангаас хишиг, хувь хүртэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй (хоёрдмол харьяалалгүй) иргэн Хүний хөгжил сангаас хишиг, хувь хүртэнэ.

Хоёр. Иргэнийг шинэчилсэн бүртгэлд бүртгэх

2.1. Хүний хөгжил сангаас хишиг, хувь хүртэх Монгол Улсын иргэнийг шинэчилсэн бүртгэлд бүртгэх ажлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн бүртгэлийн хэлтэс, газар болон сум, хорооны бүртгэлийн ажилтан тус тус гүйцэтгэнэ.

2.2. Шинэчилсэн бүртгэлд хамрагдах иргэн нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.3.1, 5.3.9, 5.3.11-5.3.13-т заасан дараах төрлийн иргэний улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ:
-төрсний;
-иргэний үнэмлэхийн (дижитал зураг);
-биеийн давхцахгүй өгөгдлийн (гарын хурууны хээ);
-иргэний байнгын оршин суугаа газрын;
-шилжилт хөдөлгөөний.

2.3. Шинэчилсэн бүртгэлийг уг бүртгэлд хамрагдах иргэнээс

холбогдох мэдээлэл (гарын хурууны хээ, дижитал зураг гэх мэт)-ийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хийнэ.

2.4. Иргэний бүртгэлийн зөрчилтэй иргэнийг шинэчилсэн бүртгэлд хамруулахгүй. Иргэн уг зөрчлөө улсын бүртгэлийн байгууллагад хандан арилгуулах үүрэгтэй.

2.5. Шинэчилсэн бүртгэл явуулах журмыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

Гурав. Хишиг, хувь хүртэх иргэний хүсэлтийг
хүлээн авах, хянан шийдвэрлэх

3.1. Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан, иргэний үнэмлэхийн бүртгэлийн код нь идэвхжсэн иргэн хишиг, хувь хүртэх хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтан болон халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (цаашид "ажилтан" гэх)-д гаргана.

3.2. Сум, хорооны ажилтан нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ дээр бичигдсэн регистрийн дугаар, иргэний бүртгэлийн кодыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн иргэний бүртгэлийн сангийн мэдээлэлтэй тулган шалгана. Бүртгэлийн зөрчилгүй иргэнд хишиг, хувь хүртэх "Хүний хөгжил сан" дэвтэр олгоно. Дэвтэрт хишиг, хувь авах иргэний овог, нэр, регистрийн дугаар, иргэний бүртгэлийн код, хишиг, хувь авах хэлбэрийг бичнэ.

3.3. Иргэн нь хишиг, хувиа Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.1, 17.1.2, 17.1.4-т заасан хэлбэрээр хүртэх хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээ үзүүлэх байгууллагын нэр, дансны дугаарыг дэвтэрт бичнэ. Иргэн сангаас эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр болон сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх, эсхүл тухайн жилд хуваарилагдсан хишиг, хувиа ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтын зорилгоор бөөн дүнгээр авах бол энэхүү журмын дөрөв, тав, зургаа дахь бүлэгт заасны дагуу авна.

3.4. Иргэний бэлэн мөнгө хэлбэрээр хүртэх хишиг, хувийг тухайн иргэнд "Хүний хөгжил сан" дэвтэр өгсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор арилжааны банкаар дамжуулан олгож байна.

3.5. Иргэний бүртгэлийн зөрчлийн улмаас иргэний бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл нь ороогүй иргэний хишиг, хувь хүртэх хүсэлтийг уг зөрчлөө арилгасны дараа хүлээж авна.

3.6. 16-гаас доош насны хүүхдийн хишиг, хувийг түүний эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-д олгоно. Гэр бүлийн тухай хуулийн

63.1.4, 64.1.4, 64.1.5-д заасан иргэний хишиг, хувийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.

3.7. Бүтэн өнчин, эцэг эх, асран хамгаалагч нь тогтоогдоогүй зэрэг шалтгаанаар асрамжийн газарт болон нийгмийн халамжийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу өрх, иргэний асрамжид байгаа, эсхүл оршин суух тодорхой хаяггүй (тэнэмэл амьдралтай) 16 хүртэлх насны хүүхдэд хүртээх хишиг, хувийг тухайн хүүхдийн нэр дээр хадгаламж нээж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн хүүхдийг асарч байгаа асрамжийн газар болон аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хадгалж, хүүхдийг 16 насанд хүрч, иргэний үнэмлэх авсны дараа өөрт нь хүлээлгэн өгнө.

3.8. Гадаадад амьдарч байгаа Монгол Улсын иргэний хүртэх хишиг, хувийг тухайн иргэний гаргасан хүсэлт, итгэмжлэл, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолтыг үндэслэн итгэмжлэгдсэн этгээдэд нь олгоно. Хэрэв тухайн иргэн итгэмжлэл гаргаагүй бол түүний хүртэх хишиг, хувь дараагийн жилд хадгалагдан үлдэнэ.

3.9. Монгол Улсын иргэн тус улсын харьяатаас гарч гадаад улсын харьяат болсон тохиолдолд сүүлийн жилд түүний хүртэх хишиг, хувийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж нэг удаа олгоно. Монгол Улсын харьяат болсон иргэнд хишиг, хувийг дараагийн жилээс нь эхлэн олгоно.

3.10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагад ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа этгээдийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын санхүүгээр дамжуулан хишиг, хувийг тухайн этгээдийн нэрийн дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх, тооцоо хийх, баталгаажуулах

4.1. Дор дурдсан иргэн Хүний хөгжил сангаас 2011 онд бэлэн мөнгө хэлбэрээр хүртэх хишиг, хувиас гадна эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр хэлбэрээр хишиг хувь хүртэж болно:

4.1.1. малчин;

4.1.2. их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч;

4.1.3. хөдөлмөр эрхлээгүй иргэн.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан иргэн нь Хүний хөгжил сангаас эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлүүлэх хүсэлтээ суманд нийгмийн

даатгалын байцаагч, аймаг, дүүрэгт нийгмийн даатгалын хэлтэст гаргана.

4.3. Сумын нийгмийн даатгалын байцаагч, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь хүсэлт гаргасан иргэний эрүүл мэндийн даатгалын гэрчилгээнд шимтгэлийн төлбөрийг хийсэн тухай тэмдэглэл хийж баталгаажуулна.

4.4. Сумын нийгмийн даатгалын байцаагч нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрөө хийлгэсэн иргэний нэрсийн жагсаалт, төлбөл зохих шимтгэлийн хэмжээг батлагдсан маягтын дагуу 2 хувь үйлдэж аймгийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын нийгмийн ажилтанд сар бүрийн 20-ны өдрөөр тасалбар болгон хүргүүлнэ.

4.5. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрөө хийлгэсэн иргэний нэрсийн жагсаалт, төлбөл зохих шимтгэлийн хэмжээг батлагдсан маягтын дагуу 2 хувь үйлдэж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст нэхэмжлэлийн хамт сар бүрийн 25-ны дотор хүргүүлнэ.

4.6. Сум, хорооны ажилтан эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрөө хийлгэсэн иргэний "Хүний хөгжил сан" дэвтэрт хишиг, хувь хүртсэн тухай бичилт хийхдээ аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн жагсаалтыг үндэслэнэ.

4.7. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн нэрсийн жагсаалт, төлбөл зохих шимтгэлийн хэмжээг тусгасан жагсаалтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүрийн 28-ны дотор хүргүүлнэ.

4.8. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрөө хийлгэсэн иргэдийн нэрсийн жагсаалт, даатгалын байгууллагын нэхэмжлэлийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дунд багтаан аймаг, дүүргээр нэгтгэн гаргаж Сангийн яамны Төрийн сангийн газарт сар бүрийн 30-ны дотор хүргүүлнэ.

4.9. Сангийн яамны Төрийн сангийн газар нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлийн нэгтгэлийг үндэслэн санхүүжилтийг сар бүрийн 5-ны дотор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн эрүүл мэндийн даатгалын

сангийн дансанд шилжүүлнэ.

4.10. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр нэхэмжлэлийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн дансанд орох хүртэлх хугацаанд сумын нийгмийн даатгалын байцаагч, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нэхэмжлэлийн дүнг нийгмийн даатгалын сангийн "авлагын дансанд" Хүний хөгжил сангаас төлөхөөр бүртгэж, тайлагнана.

4.11. Хүний хөгжил сангаас эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр хэлбэрээр олгох хишиг, хувьтай холбоотой өглөг, авлагын тооцоог холбогдох байгууллагууд сар бүр нийлж, актаар баталгаажуулж байна.

4.12. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь өөрийн харьяа нутаг дэвсгэрт байрлах их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс өдрийн ангийн суралцагчдын бүртгэлийн жагсаалтыг гаргуулан авч эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтэй суралцагчдыг бүртгэх, хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулна.

Тав. Сургалтын төлбөр төлөх, тооцоо хийх, баталгаажуулах

5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн их, дээд, сургууль, коллежийн өдрийн ангид дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалд 2010-2011 оны хичээлийн жилд суралцаж байгаа иргэн (цаашид "суралцагч" гэнэ) Хүний хөгжил сангаас 2011 онд бэлэн мөнгө хэлбэрээр хүртэх хишиг, хувиас гадна сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэж болно.

5.2. Суралцагч сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтээ сум, хорооны ажилтанд гаргана. Хэрэв өөрийн биеэр хүсэлт гаргах боломжгүй бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл эхнэр, нөхөр нь түүний өмнөөс хүсэлт гаргаж болно.

5.3. Хүсэлтэд суралцагчийн овог нэр, регистрийн дугаар, нас, хүйс, суралцаж байгаа сургууль, мэргэжил, дамжаа зэргийг тодорхой дурдсан байна.

5.4. Сум, хорооны ажилтан, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлт гаргасан суралцагчийн хувийн хэрэгт нь бичилт хийж, тухайн иргэний нэр, хаяг, суралцаж байгаа сургуулийн талаархи мэдээллийг багтаасан жагсаалтыг батлагдсан маягтын дагуу гаргаж нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.5. Их, дээд сургууль, коллеж нь 2010-2011 оны хичээлийн жилд

суралцаж байгаа суралцагчийн нэрсийн жагсаалтыг аймаг, сум, дүүрэг, хороогоор (иргэний үнэмлэх дээр бичигдсэн хаягийн дагуу) батлагдсан маягтын дагуу үнэн зөв дэлгэрэнгүй гаргаж баталгаажуулан, Сургалтын төрийн санд цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

5.6. Сургалтын төрийн сан нь их, дээд сургууль, коллежоос ирүүлсэн суралцагчдын нэрсийн жагсаалтыг сургалтын төрийн сангийн мэдээллийн сантай тулган шалгаж, аймаг, сум, дүүрэг, хороогоор нэгтгэн баталгаажуулж, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр болон албан бичгээр ирүүлнэ.

5.7. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Сургалтын төрийн сангаас ирүүлсэн суралцагчдын нэрсийн жагсаалтыг энэхүү журмын 5.4-т заасан жагсаалттай тулган шалгасны үндсэн дээр их, дээд сургууль, коллежид суралцагчийн сургалтын төлбөр хэлбэрээр хүртэх хишиг, хувийн санхүүжилтийн хэмжээг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дунд багтаан сургууль тус бүрээр гаргаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

5.8. Сангийн яамны Төрийн сангийн газар нь Хүний хөгжил сангаас энэхүү журмын 5.7-д заасан хөрөнгийг Сургалтын төрийн санд шилжүүлнэ.

5.9. Сургалтын төрийн сан нь суралцагчийн сургалтын төлбөр хэлбэрээр хүртэх хишиг, хувийг их, дээд сургууль, коллежийн харилцах дансанд шилжүүлнэ.

5.10. Хүний хөгжил сангаас суралцагчийн сургалтын төлбөр хэлбэрээр хүртэх хишиг, хувийг шилжүүлснээр суралцагчийн төлсөн төлбөр нь тухайн жилийн төлбөл зохих хэмжээнээс илүү гарч байгаа тохиолдолд их, дээд сургууль, коллеж нь ийнхүү илүү төлөгдсөн хэсгийг дараа оны сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно. Хэрэв суралцагч нь төгсөх дамжааны оюутан бол түүнд их, дээд сургууль, коллеж нь төлбөрийн зөрүүг буцаан олгоно.

5.11. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Хүний хөгжил сангаас сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртсэн суралцагчийн тухай мэдээллийг аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, сум, хорооны ажилтанд цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

5.12. Сум, хорооны ажилтан, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь цахим мэдээлэл болон албан бичгийг

үндэслэн сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртсэн суралцагчийн "Хүний хөгжил сан" дэвтэрт нь бичилт хийнэ.

Зургаа. Ажлын байр бий болгох, хөрөнгө оруулалтын зорилгоор хишиг, хувийг нэг удаа бөөн дүнгээр бэлэн бусаар хүртэх иргэдийн хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх

6.1. Улсын Их Хурлын 2010 оны 67 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу энэ журмын 1.2-т заасан иргэд өөрсдийн санаачилгаар нэгдэж, 10 сая төгрөгөөс доошгүй хэмжээнд хөрөнгө оруулж ажлын байр бий болгох зорилгоор Хүний хөгжил сангаас сар бүр бэлэн мөнгөөр хүртэх хишиг, хувийг нэг удаа бөөн дүнгээр нь бэлэн бусаар хүртэж болно.

6.2. Энэ журмын 6.1-д заасны дагуу хишиг, хувиа нэг удаа бөөн дүнгээр нь бэлэн бусаар хүртэх иргэд нь энэ тухай гарын үсэг зурж нотариатаар баталгаажуулсан хүсэлт, Иргэний хуулийн 190.2-т заасны дагуу байгуулж нотариатаар гэрчлүүлсэн гэрээ, шинээр хоршоо, нөхөрлөл, жижиг, дунд үйлдвэр байгуулсан тухай албан ёсны шийдвэр, материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэрэг үйлдвэрлэлийн зориулалт бүхий эд зүйлс худалдан авах тохиолдолд үнийн нэхэмжлэл зэрэг бичиг баримтыг бүрдүүлнэ. Хишиг, хувиа нэг удаа бөөн дүнгээр нь бэлэн бусаар хүртэх тухай хүсэлтэд 16 нас хүрсэн иргэн бүр гарын үсэг зурна.

6.3. Энэхүү журмын 6.2-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн хишиг, хувиа нэг удаа бөөн дүнгээр нь бэлэн бусаар хүртэх хүсэлтээ иргэд сум, хорооны Засаг даргаар баталгаажуулан сум, хорооны ажилтанд өгнө.

6.4. Сум, хорооны ажилтан нь хишиг, хувиа нэг удаа бөөн дүнгээр бэлэн бусаар хүртэхээр нэгдсэн иргэдийн судалгааг гаргаж, шаардагдах хөрөнгийн тооцоог хянан, сар бүрийн 20-ны дотор аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлнэ.

6.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь сум, хорооноос ирүүлсэн тооцоо, судалгааг хянан үзэж, нэгтгэн сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгож нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.6. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дээрх судалгаа, тооцоог хянан үзэж, батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дунд багтаан Хүний хөгжлийн сангаас нэг удаа бөөн дүнгээр бэлэн бусаар хишиг, хувь хүртэх иргэдэд олгох хөрөнгийг аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст шилжүүлнэ.

6.7. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь

нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн нэг удаа бөөн дүнгээр бэлэн бусаар хишиг, хувь хүртэх иргэдэд олгох хөрөнгийг харьяа арилжааны банкаар дамжуулан шилжүүлж, энэ тухай иргэн бүрийн "Хүний хөгжил сан" дэвтэрт бичилт хийнэ.

6.8. Арилжааны банк нь хүсэлт гаргасан иргэдээс санал болгосон аж ахуйн нэгж, байгууллагын харилцах дансанд хишиг, хувийн мөнгийг шилжүүлнэ.

6.9. Энэхүү журмын 6.1-д заасан иргэд нь аж ахуй эрхлэх туршлагагүй бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тэдгээрийг аж ахуй эрхлэх сургалтад хамруулж болно.

Долоо. Сургалтын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийн хэмжээ

7.1. Хүний хөгжил сангаас 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр болон оюутны сургалтын төлбөрийн хэлбэрээр хүртэх хишиг, хувь дор дурдсан хэмжээтэй байна:

7.1.1. энэхүү журмын 4.1-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээ Засгийн газраас тогтоосноор 670 (зургаан зуун далан) төгрөг;

7.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн өдрийн ангид дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалд 2010-2011 оны хичээлийн жилд суралцагчийн сургалтын төлбөр хэлбэрээр хүртэх хишиг, хувийн хэмжээ нь 500000 (таван зуун мянган) төгрөг .

Найм. Хишиг, хувь хүртэх хугацаа

8.1. Монгол Улсын иргэнд хишиг, хувийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу Улсын Их Хурлаас тухайн жилд тогтоосон хэмжээгээр олгоно. Иргэн энэхүү хишиг, хувийг тухайн жилд хүртэж чадаагүй бол дараагийн жилүүдэд нөхөн авч болно.

8.2. Энэхүү журмын 6 дугаар бүлэгт заснаас бусад тохиолдолд иргэнд хишиг, хувийг урьдчилж олгохгүй.

Ес. Бэлэн мөнгөний хэлбэрээр сар бүр хишиг, хувь хүртэхэд бүрдүүлэх бичиг баримт

9.1. Хишиг, хувь хүртэх иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

9.1.1. иргэний үнэмлэх;

9.1.2. 16-гаас доош насны хүүхдийн хувьд төрсний гэрчилгээ, эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний үнэмлэх;

9.1.3. хэрэв хүүхэд асрамжийн газарт байгаа бол тухайн асрамжийн газрын тодорхойлолт;

9.1.4. Гэр бүлийн тухай хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг даргын шийдвэр, түүний хуулбар;

9.1.5. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 16.2-т заасан иргэний хишиг, хувийг авах бол нас барсны гэрчилгээ, түүний хуулбар;

9.1.6. гадаадад амьдарч байгаа Монгол Улсын иргэний хувьд хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолт, итгэмжлэл.

Арав. Бусад

10.1. Иргэн хишиг, хувь хүртэх асуудлаар сум, хорооны ажилтны тавьсан шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол гомдлоо сум, хорооны Засаг дарга, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст гаргаж болно. Гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Иргэн сум, хорооны Засаг дарга болон аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол маргаанаа нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар шийдвэрлүүлнэ.

10.2. Хишиг, хувь хүртэж байгаа иргэн шилжих тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага оршин суугаа хаягийн өөрчлөлтийг хийж, тухайн орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс шилжих хүртэлх хугацаанд уг иргэний хүртсэн хишиг, хувийн хэмжээний талаар тодорхойлолтыг олгоно.

10.3. Энэхүү журмын 10.2-т заасан тодорхойлолтыг үндэслэн иргэнд шилжин ирсэн газрын хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, сум, хорооны ажилтан хишиг, хувийг үргэлжлүүлэн олгоно.

10.4. Сургалтын төлбөр олгохтой холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Шилжин суралцахтай холбогдон гарах сургалтын төлбөрийн тооцооны асуудлыг тухайн сургуульд хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрэм, журмыг баримтлан зохицуулна.

10.5. Энэхүү журмын 4.4, 5.4, 5.5-д заасан маягтын загварыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6. Энэхүү журамд заасан бичиг баримтыг хуурамчаар үйлдэж хишиг, хувь хүртэх нөхцөл бүрдүүлсэн албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

10.7. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 16.1-д заасан тохиолдолд сум, хорооны ажилтан нь тухайн иргэний хишиг, хувь хүртэх эрх дуусгавар болсон тухай "Хүний хөгжил сан" дэвтэрт тэмдэглэл хийнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 348 | Улаанбаатар хот |

**Гадаадаас 2011 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2011 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заагаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар, дотоодын төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны зөвшөөрөл бүхий гадаадын төрийн бус байгууллагад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 30 хүртэл хувь байхаар тус тус батлсугай.

3. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД** — **Т.ГАНДИ**

Засгийн газрын 2010 оны 348 дугаар
тогтоолын хавсралт

## БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН 2011 ОНД ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ

| Салбар | Дэд салбар | Бүлэг | Анги | Тодорхойлолт | Дүрмийн сан /сая төг/ | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 50 хүртэл | | | 51-100 | | | 101-500 | | | 501-ээс дээш | | |
| | | | | | Нийт ажиллагчдын тоо | | | | | | | | | | | |
| | | | | | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш | 50 хүртэл | 51-100 | 101-ээс дээш |
| A | | | | ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС БАРИЛТ, АН АГНУУР | | | | | | | | | | | | |
| | 01 | | | Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд туслах үйл ажиллагаа | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| B | | | | УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ | | | | | | | | | | | | |
| | 06 | | | Түүхий газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт | 60 | 70 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 | 75 |
| | 09 | 099 | 0990 | Уул уурхайн хайгуул, олборлолтын бусад туслах үйл ажиллагаа | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 |
| C | | | | БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ | | | | | | | | | | | | |
| | 10 | | | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 13 | | | Нэхмэлийн үйлдвэрлэл | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 20 | | | Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| | 23 | | | Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 5 | 10 | 15 | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 |
| | 24 | | | Металл үйлдвэрлэл | 5 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 15 | 20 | 20 | 20 |
| | 32 | | | Бусад боловсруулах үйлдвэрлэл | 8 | 9 | 10 | 9 | 10 | 11 | 10 | 11 | 12 | 11 | 12 | 13 |
| D | | | | ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТЫН ХАНГАМЖ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| E | | | | УСАН ХАНГАМЖ, БОХИР УС, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| F | | | | БАРИЛГА | | | | | | | | | | | | |
| | 41 | 410 | 4100 | Барилга угсралт | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 | 30 | 35 | 40 |
| | | | | Уул уурхайн барилга угсралт, бусад | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 | 30 | 35 | 40 | 40 | 40 | 40 |
| | | 421 | 4210 | Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 | 30 | 35 | 40 | 35 | 40 | 45 |
| G | | | | БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 45 | | | Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| H | | | | ТЭЭВЭР БОЛОН АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | | | | | |
| I | | | | БАЙР, СУУЦ БОЛОН ХООЛ ХҮНСЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 5 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 15 | 20 | 20 | 20 |
| | 55 | | | Байр, сууцаар хангах үйл ажиллагаа | 5 | 5 | 5 | 10 | 10 | 10 | 15 | 15 | 15 | 20 | 20 | 20 |
| | 56 | | | Хоол үндэсээр үйлчлэх үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| M | | | | МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| | 72 | | | Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, олонт, судалгааны үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| N | | | | ЗАХИРГААНЫ БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 10 | 15 | 20 | 15 | 20 | 25 | 20 | 25 | 30 | 25 | 30 | 35 |
| | | 791 | | Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| P | 85 | | | БОЛОВСРОЛ | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |
| | | 851,852,854 | | Бага болон бүрэн дунд, бусад боловсрол олгох үйл ажиллагаа | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| | | 853 | 8522 8530 | Техник мэргэжлийн дунд боловсрол болон дээд боловсрол олгох үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| Q | | | | ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БОЛОН НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 86 | | | Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
| | 87 | | | Оршин суугчдад үзүүлэх халамжийн үйл ажиллагаа | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
| | 88 | | | Зориулалтын байргүй нийтийн тусламжийн үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| R | | | | УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| | 90 | 900 | 9000 | Бүтээлч туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| | 93 | | | Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| S | | | | ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 95 | | | Хувийн болон өрхийн хэрэглээний бараа, компьютерийн засвар, үйлчилгээ | 5 | 6 | 7 | 6 | 7 | 8 | 7 | 8 | 9 | 8 | 9 | 10 |
| | 96 | 960 | | Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |
| U | | | | ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |
| | 99 | 990 | 9900 | Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | | | | | | | | | | | | |

Жич: 20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад гадаадын 1 иргэн байж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 349 | Улаанбаатар хот

**2011 оныг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2011 оныг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгон зарласугай.

2. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил"-ийн ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батласугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн ажлын хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, явц, дүнг улирал тутам Засгийн газарт танилцуулж байхыг Үндэсний хороонд даалгасугай.

4. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил"-ийн ажлыг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, тухайн салбар болон орон нутгийн хэмжээнд шинээр бий болсон ажлын байрны тоо, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг Үндэсний хороонд улирал тутам тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил"-ийн ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны үйл ажиллагааны зардалд зориулан 70.0 (далан) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** — **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** — **Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2010 оны 349 дүгээр
тогтоолын хавсралт

**"ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЖИЛ"-ИЙН АЖЛЫГ УЛСЫН ХЭМЖЭЭНД УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд

Гишүүд: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди;

-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр;
-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай;
-Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр;
-Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын дарга Н.Бямбасүрэн;
-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайхан;
-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Л.Нямсамбуу (тохиролцсоноор);
-Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч С.Ганбаатар (тохиролцсоноор);
-Ерөнхий сайдын зөвлөх С.Чинзориг.
Нарийн бичгийн дарга
-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар (тохиролцсоноор)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 350 | Улаанбаатар хот |

**"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжүүдэд худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 17 дугаар зүйлийн 17.4, Улсын Их Хурлын 2010 оны 39, 69 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрд ногдох ашгаас Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээх, хувьцаа эзэмшүүлэх загварыг хавсралт ёсоор батлсугай.

2. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх, аж ахуйн нэгжид нэрлэсэн үнээр худалдах ажлын бэлтгэл хангах хүрээнд дор дурдсан арга хэмжээг 2011 оны 2 дугаар сард багтаан хэрэгжүүлж, үр дүнг Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, "Монголын хөрөнгийн бирж" ХК, "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д тус тус даалгасугай:

2.1. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 10 хувийг

2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдэд эзэмшүүлэхээр тооцож нэр, оршин суугаа хаяг болон үнэт цаасны данс нээх асуудалтай холбоотой бусад мэдээллийг агуулсан иргэдийн мэдээллийн санг бий болгох.

2.2. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааны 10 хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө байгуулагдаж анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргасан, гадаадын хөрөнгө оруулалт нь 25 хувиас хэтрээгүй, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоогүй компани, хоршоо, нөхөрлөлд нэрлэсэн үнээр худалдахаар тооцож тэдгээрийн нэр, тоо, байршил болон үнэт цаасны данс нээх асуудалтай холбоотой бусад мэдээллийг агуулсан аж ахуйн нэгжийн мэдээллийн санг бий болгох.

2.3. Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн болон аж ахуйн нэгжид нэрлэсэн үнээр худалдсан "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааг түүний 2 дахь зах зээл нээгдэх хүртэл бусдад зарах, шилжүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

2.4. "Хувьцаа эзэмших батламж бичиг"-ийн загвар, түүнийг ашиглах зааврын төслийг боловсруулж танилцуулах.

3."Эрдэнэс-Тавантолгой"ХК-ийнүнэлгээхийжиргэдэдэзэмшүүлэх, аж ахуйн нэгжид худалдах хувьцааны тоо, нэрлэсэн үнийг тогтоох талаар сонгон авсан зөвлөх компанитай хамтран санал боловсруулж 2011 оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), "Эрдэнэс МГЛ" ХХК-д даалгасугай.

4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 30 хүртэлх хувийг 2011 онд багтаан олон улсын хөрөнгийн зах зээлд гаргах бэлтгэл ажлыг хангах зорилгоор хөрөнгө оруулалтын банк, аудитын болон хуулийн зөвлөгөө өгөх компанийг сонгон шалгаруулж 2011 оны I улиралд багтаан гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

5. Энэ тогтоолын 3, 4 дүгээр зүйлд заасан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг "Эрдэнэс МГЛ" ХХК (Б.Энэбиш)-д зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,**
**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ**
**ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын хавсралт

**СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТӨРД НОГДОХ АШГААС МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ХИШИГ, ХУВЬ ХҮРТЭЭХ, ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ЗАГВАР**




**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
Утас: 262323, 329612
Хэвлэлийн хуудас 2
**Индекс: 14003**



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас: 329487